



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот


Г
Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга
нарыг томилох тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 126 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад зааснаар тус тус баталсугай.

2. Яам, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад зааснаар тус тус томилсугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай" 2010 оны 74, 2011 оны 88, 2012 оны 42, 57, 137, 152, 155, 2013 оны 78 дугаар тогтоолууд, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 2011 оны 102, 2012 оны 67, 111, 117, 118, 125, 126, 128, 129, 130, 138, 145, 148, 149, 150, 151, 156, 164, 2013 оны 05, 79 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 6 дугаар
сарын 22-ны өдрийн 13 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

НЭГ. ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

- 1) Төрийн нарийн бичгийн дарга,
- 2) Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,
- 3) Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга,
- 4) Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга,
- 5) Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,
- 6) Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,
- 7) Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга,
- 8) Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
- 9) Төрийн захиргааны удирдлагын газрын салбарын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн.

2. Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

- 1) Төрийн нарийн бичгийн дарга,
- 2) Ази, Номхон далайн орнуудын газрын захирал,
- 3) Америк, Африкийн газрын захирал,
- 4) Бодлого төлөвлөлт, судалгааны газрын захирал,
- 5) Гэрээ, эрх зүйн газрын захирал,
- 6) Европ, Ойрхи Дорнодын газрын захирал,
- 7) Консулын газрын захирал,
- 8) Олон улсын байгууллагын газрын захирал,
- 9) Төрийн захиргааны удирдлагын газрын захирал,
- 10) Хөрш орнуудын газрын захирал,
- 11) Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал,
- 12) Төрийн захиргааны удирдлагын газрын зөвлөх (хүний нөөцийн асуудал хариуцсан).

3. Сангийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

- 1) Төрийн нарийн бичгийн дарга,
- 2) Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,
- 3) Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга,
- 4) Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга,
- 5) Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газрын дарга,
- 6) Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын дарга,
- 7) Төрийн сангийн газрын дарга,
- 8) Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын газрын дарга,
- 9) Төрийн захиргааны удирдлагын газрын санхүү, зохион байгуулалтын хэлтсийн

3.Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

- 1) Цагдаагийн ерөнхий газрын дарга,
- 2) Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга,
- 3) Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга,
- 4) мөн газрын Захиргааны удирдлагын газрын дарга,
- 5) мөн газрын Бодлого, зохицуулалт, үнэлгээний хэлтсийн дарга,
- 6) мөн газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга,
- 7) мөн газрын Хуулийн хэлтсийн дарга,
- 8) Дотоодын цэргийн штабын дарга,
- 9) Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн ахлах байцаагч.

4.Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

- 1) Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
- 2) Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга,
- 3) Захиргааны удирдлага, хангарт хариуцсан дэд дарга,
- 4) Дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан дэд дарга,
- 5) Хилийн тагнуулын газрын дарга,
- 6) Хилийн албаны хэлтсийн дарга,
- 7) Хүний нөөцийн хэлтсийн дарга,
- 8) Хил хамгаалах ерөнхий газрын Тамгын хэлтсийн хуулийн зөвлөх,
- 9) Хүний нөөцийн хэлтсийн офицерийн бүрэлдэхүүн хариуцсан хүний нөөцийн ахлах мэргжилтэн.

5.Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

- 1) Зэвсэгт хүчний жанжин штабын дарга,
- 2) Зэвсэгт хүчний жанжин штабын дэд дарга,
- 3) Зэвсэгт хүчний жанжин штабын ахлагч,
- 4) Ажиллагааны удирдлагын газрын дарга,
- 5) Хяналт, шалгалт, үнэлгээний газрын дарга,
- 6) Цэргийн хангарт, үйлчилгээний газрын дарга,
- 7) Ерөнхий зориулалтын цэргийн командлагч,
- 8) Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч,
- 9) Хүний нөөцийн хэлтсийн дарга.

6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

- 1) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга,
- 2) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга,
- 3) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга,
- 4) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга,
- 5) Шийдвэр гүйцэтгэх газрын дарга,
- 6) Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтсийн дарга,
- 7) Хүний нөөц сургалтын хэлтсийн дарга,



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий
газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг", Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний:

- 3)-т "Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга" гэснийг "Цагдаагийн ерөнхий газрын Дэмжлэгүзүүлэх асуудал-эрхэлсэн дэд дарга" гэж,
- 4)-т "мөн газрын Захиргааны удирдлагын газрын дарга" гэснийг "Дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн дэд дарга" гэж,
- 5)-д "мөн газрын Бодлого, зохицуулалт, үнэлгээний хэлтсийн дарга" гэснийг "Гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга" гэж,
- 6)-д "мөн газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга" гэснийг "Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтсийн дарга" гэж,
- 7)-д "мөн газрын Хуулийн хэлтсийн дарга" гэснийг "Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга" гэж,
- 8)-д "Дотоодын цэргийн штабын дарга" гэснийг "Хуулийн хэлтсийн дарга" гэж,
- 9)-д "Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн ахлах байцаагч" гэснийг "Хүний нөөц, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн" гэж тус тус өөрчилсүгэй.

ДАРГА

Б.ЦОГОО

